



НИЙСЛЭЛИЙН ОНЦГОЙ КОМИСС

Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
4 дүгээр хороо, Ж.Самбуугийн гудамж 13, 15140-0036
Утас/Факс: (976-11) 31-83-92
E-mail: nok@ulaanbaatar.mn
http://www.nobg.ub.gov.mn

2021. 10. 15 № 668

танай _____-ны № _____-т

НИЙСЛЭЛИЙН НУТГИЙН ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГУУДАД

Улсын Онцгой комиссын 2021 оны 09 дүгээр сарын 27-ны өдрийн 27 дугаар хурлын тэмдэглэлийн 8.1, 8.2, 2021 оны 10 дугаар сарын 12-ны өдрийн шуурхай ажлын хэсгийн хурлын 3 дахь заалтын хүрээнд халдвар хамгааллын дэглэмийг мөрдүүлж, ажлын байрны халдварын нөхцөл байдалд эрсдлийн үнэлгээ хийж, ахмад ажилтан, архаг суурь өвчтэй, жирэмсэн, 0-12 насны хүүхэдтэй эцэг эхчүүдийг цахимаар ажиллуулах боломжийг хангаж ажиллахыг зөвлөж байна.

Хавсралт 4 хуудастай.

ОРЛОГЧ ДАРГА



Р.ЧИНГИС



УЛСЫН ОНЦГОЙ КОМИССЫН
ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2021 оны 9 сарын 27 өдөр

Дугаар 27

Улаанбаатар хот

XXVII ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

Улсын онцгой комиссын хуралдааныг 2021 оны 9 дүгээр сарын 27-ны өдрийн 15:00 цагт Төрийн ордон дахь “Чингис хаан танхим”-д 27 хувийн ирцтэй хуралдуулав.

Хуралдааныг Монгол Улсын Шадар сайд, Улсын онцгой комиссын дарга С.Амарсайхан даргалж, холбогдох шийдвэрийг гаргаж, хугацаатай үүрэг даалгавар өгөв.

ХЭЛЭЛЦСЭН АСУУДАЛ:

1. Коронавируст халдвар /Ковид-19/-ын нөхцөл байдал, авч хэрэгжүүлж буй хариу арга хэмжээний талаар

*Эрүүл мэндийн сайд,
Улсын онцгой комиссын гишүүн С.Энхболд*

2. Коронавируст халдвар /Ковид-19/-ын тархалтын түвшинг тогтоож, төрийн байгууллага, хүн, хуулийн этгээдийн үйл ажиллагааг зохицуулах түр журам болон “Коронавируст халдвар /Ковид-19/-аас сэргийлэх арга хэмжээг зохион байгуулах түр журамд оруулах нэмэлт өөрчлөлтийн талаар

*Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын Эрүүл мэнд, боловсрол, соёлын
хяналтын газрын дарга С.Сүнчин*

3. Бусад /“Эрдэнэт медикал” оношлогоо-эмчилгээний төвийн талаар,
Улсын онцгой комиссын даргын тушаалын хэрэгжилтийн талаар/

*Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын дарга
Б.Цэнгэл,
Улсын онцгой комиссын нарийн бичгийн дарга Т.Баярхүү*

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

Нэг. Улсын онцгой комиссын гишүүн, Эрүүл мэндийн сайд С.Энхболд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт:

1.1. Гэрээр тусгаарлагдан эмчлэгдэж байгаа коронавируст халдвар /Ковид-19/-ын батлагдсан тохиолдолд үзүүлж буй эмнэлгийн тусламж үйлчилгээ, эм, эмийн хэрэгслийн чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх зохион байгуулалтын арга хэмжээ авч хэрэгжүүлэх, гүйцэтгэлд хяналт тавьж, биелэлтийг 2021 оны 10 дугаар сарын 15-ны өдрийн дотор Улсын онцгой комисст танилцуулах;

1.2. Коронавируст халдвар /Ковид-19/-ын дельта хувилбарын тархалтын оргил үеийн хугацаанд хүндрэл, нас баралтаас сэргийлэх зорилгоор халдвар авсан иргэдийг эмчлэх эмнэлгийн ор, тусгаарлан эмчлэх байр болон эмч, эмнэлгийн ажилтнуудыг хуваарилан ажиллуулах төлөвлөгөөнд нэн даруй тодотгол хийж, эрсдэлт бүлэгт эмнэлгийн тусламж үйлчилгээг цаг алдалгүй үзүүлэх зохион байгуулалтын арга хэмжээ авч хэрэгжүүлэх;

1.3. Коронавируст халдвар /Ковид-19/-аар өвдсөн хүүхдийн эмчилгээний талаар эцэг эхчүүдэд зөвлөгөө, мэдээлэл өгөх зорилготой лавлах утас, цахимаар зөвлөгөө өгөх шугам 2021 оны 10 дугаар сарын 01-ний дотор байгуулж, 24 цагийн турш тогтмол ажиллуулж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах;

1.4. Эм, эмнэлгийн хэрэгсэл, оношлуур, халдваргүйжүүлэлтийн бодис, хамгаалах хувцас хэрэгслийн шаардлагатай нөөцийг тогтмол бүрдүүлж, хяналт тавих;

Хоёр. Улсын онцгой комиссын гишүүн, Боловсрол шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан, Эрүүл мэндийн сайд С.Энхболд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт:

2.1. Их, дээд сургуулийн дотуур байранд Коронавируст халдвар /Ковид-19/ илэрсэн тохиолдолд хариу арга хэмжээ авч хэрэгжүүлэх төлөвлөгөө, журмыг шинэчлэн боловсруулж, бэлэн байдлыг хангах, халдварын шинж тэмдэг илэрсэн тохиолдолд баталгаажуулах шинжилгээ авах ажлыг харьяа дүүргийн Эрүүл мэндийн төвтэй хамтран зохион байгуулах;

2.2. Дотуур байранд батлагдсан тохиолдлыг /хөнгөн/ тусгаарлан эмчлэх байрыг халдвартай, завсрын, халдваргүй бүс, хоол хүнсний нөөцийн хэсэг, харуул, тогооч, үйлчилгээний ажилчдын байрлах хэсэг, халдвартай хог хаягдал хадгалах хэсэг, агааржуулалтын систем зэрэг шаардлагыг хангаж, зохион байгуулж ажиллах;

2.3. Дотуур байранд батлагдсан тохиолдлын хүнд, маш хүнд хэлбэрийг хэвтүүлэн эмчлэх, хөнгөн хэлбэрийн өвчлөлд эмийн багц олгох, багш, ажилчид батлагдсан тохиолдолд хариу арга хэмжээ хэрэгжүүлэх заавар, журмыг баталж, хэрэгжүүлэх;

2.4. Их, дээд сургуулиудын оюутны дотуур байранд байгаа оюутнууд коронавирусын халдвар авахад эрүүл мэндийн байгууллагын ажлын ачааллаас шалтгаалан тандалтын баг, өрхийн эрүүл мэндийн байгууллагын хяналтад орохгүй, тусгаарлагдахгүй бусад оюутнуудтай хамт амьдарч халдвар тараах эрсдэл өндөр

байгаа тул хөнгөн хэлбэрээр өвчилсөн оюутнуудыг тусгаарлах байрны асуудлыг нэн даруй шийдвэрлэх;

2.5. Их дээд сургууль, ерөнхий боловсролын болон сургуулийн өмнөх боловсролын байгууллагын хичээл сургалтын үндсэн хөтөлбөрөөс гадуурх танхимын бус сургалт, танилцах үдэшлэг, оюутны хөгжлийн клуб, өдөрлөг, тэмцээн уралдаан, аялал, зугаалга, багш нарын баяр болон бусад тэмдэглэлт арга хэмжээг зохион байгуулахгүй байх, “Сургууль-гэр-сургууль” маршрутыг баримталж ажиллах талаар бүх шатны боловсролын байгууллагуудад чиглэл өгч, хяналт тавьж ажиллах.

Гурав. Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын дарга Л.Бямбасүрэнд:

3.1. Коронавируст халдвар /Ковид-19/-ын хөнгөн хэлбэрийн гэрээр хянаж эмчилсэн тохиолдлын гүйцэтгэлийн санхүүжилтийг цаг тухайд нь товлосон хугацаанд нь хоцрогдолгүй олгох, санхүүжилт хоцорсон анхан шатны эрүүл мэндийн байгууллагын санхүүжилтийг нөхөж олгох;

Дөрөв. Улсын онцгой комиссын гишүүн, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд З.Мэндсайхан, Мал эмнэлгийн ерөнхий газрын дарга Б.Ганзориг нарт:

4.1. Дорнод аймгийн Чулуунхороот суманд олон улсын хорио цээрт “Үхрийн арьс товруутах өвчин” шинээр оношлогдсонтой холбогдуулан “Мал, амьтны гоц халдварт, халдварт өвчний жагсаалт батлах тухай” Засгийн газрын 2018 оны 7 дугаар сарын 9-ний өдрийн 225 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтад “Үхрийн арьс товруутах” өвчнийг нэмэлтээр оруулах асуудлыг Засгийн газрын хуралдаанд оруулж хэлэлцүүлэн, шийдвэрлүүлэх;

Тав. Улсын онцгой комиссын гишүүн, Эрүүл мэндийн сайд С.Энхболд, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч Д.Сумъяабазар нарт:

5.1. Коронавируст халдвар /Ковид-19/-ын тусламж, үйлчилгээний зураглалыг нийслэл болон орон нутгийн түвшинд тохируулан шинэчлэх, эмнэлгийн болон эмнэлгийн бус байрны орны зохицуулалтыг хийх ажлын хэсгийг байгуулж ажиллах;

Зургаа. Аймаг, нийслэлийн Засаг дарга нарт:

6.1. Коронавируст халдвар /Ковид-19/-ын дельта хувилбарын тархалтын оргил үеийн хугацаанд халдварын тархалт, эмнэлгийн ачаалал огцом нэмэгдэж, эмнэлгийн тусламж үйлчилгээ хоцрох, хүндрэл, нас баралт нэмэгдэж байгаа өндөр эрсдэлтэй нөхцөл байдлыг харгалзан үзэж, Эрүүл мэндийн яам, Халдварт өвчин судлалын үндэсний төвийн саналыг үндэслэн амны хаалттай үйлчлүүлэх боломжгүй, халдвар тархах өндөр эрсдэлтэй бүх төрлийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний газруудын үйл ажиллагааг 2021 оны 10 дугаар сарын 31-ний өдрийг дуустал 22.00 цаг хүртэл хязгаарлаж, шийдвэрийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах;

Долоо. Засгийн газрын хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах газрын дарга Т.Ганзул болон Аймаг, нийслэлийн Засаг дарга нарт:

7.1. Амны хаалттай үйлчлүүлэх боломжгүй аж ахуйн нэгж байгууллагууд хүний бөөгнөрөл үүсгэхгүй байх, халдварын давалгааны оргил үед халдвараас урьдчилан сэргийлэх арга хэмжээ авч хариуцлагатай байх уриалга, санаачилга гаргах, энэ талаар мэдээлэл, сурталчилгааны ажил тогтмол зохион байгуулах;

Найм. Улсын онцгой комиссын гишүүн, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын тэргүүн дэд дарга Б.Ганбат, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт:

8.1. Коронавируст халдвар /Ковид-19/-ын дельта хувилбарын тархалтын оргил үеийн хугацаанд халдварын тархалт, эмнэлгийн ачаалал огцом нэмэгдэж, эмнэлгийн тусламж үйлчилгээ хоцрох, хүндрэл, нас баралт нэмэгдэж байгаа өндөр эрсдэлтэй нөхцөл байдлыг харгалзан үзэж, байгууллага, аж ахуйн нэгжүүд дотоод орчинд халдвараас урьдчилан сэргийлэх зохион байгуулалтын арга хэмжээ авч хэрэгжүүлэх;

8.2. Байгууллага, ажлын байрны халдварын нөхцөл байдлыг харгалзан үзэж тодорхой хувийг цахимаар, зайнаас ажиллуулах, эрсдэлт бүлгийг халдвараас хамгаалах арга хэмжээг авч хэрэгжүүлж, халдвар тархах эрсдэлээс урьдчилан сэргийлж ажиллах;

Ес. Улсын онцгой комиссын гишүүн, Эрүүл мэндийн сайд С.Энхболд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын тэргүүн дэд дарга Б.Ганбат, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч Д.Сумъяабазар, Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын дарга Т.Гантулга, Халдварт өвчин судлалын үндэсний төвийн захирал Ц.Билэгтсайхан, Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төвийн захирал Д.Нарантуяа, Улсын онцгой комиссын дэргэдэх Эрдэмтдийн зөвлөлийн дарга, хурандаа Ж.Амгалан нарт:

9.1. Коронавируст халдвар /Ковид-19/-ын эсрэг вакцинд нийт хүн ам болон зорилтот бүлэг өндөр хувьтай хамрагдсан нөхцөл байдлыг харгалзан цаашид халдварын тархалтын түвшинд зохицуулан аж ахуйн нэгж, байгууллага, хүн, хуулийн этгээдийн үйл ажиллагааг тасралтгүй явуулах зорилгоор Засгийн газрын 2021 оны 5 дугаар сарын 5-ны өдрийн 118 дугаар тогтоолоор баталсан “Коронавируст халдвар /Ковид-19/-ын тархалтын түвшинг тогтоож, төрийн байгууллага, хүн, хуулийн этгээдийн үйл ажиллагааг зохицуулах түр журам”-д өөрчлөлт оруулах төслийг хамтарсан ажлын хэсэг байгуулан боловсруулж, 2021 оны 10 дугаар сарын 15-ны өдөр Улсын онцгой комисст танилцуулж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэн батлуулах;

9.2. Улсын онцгой комиссын даргын 55 дугаар тушаалаар байгуулагдсан Ажлын хэсэг “Коронавируст халдвар /Ковид-19/-аас сэргийлэх арга хэмжээг зохион байгуулах түр журамд оруулах нэмэлт өөрчлөлтийн төслийг эцэслэн боловсруулж 2021 оны 10 дугаар 10-ны өдрийн дотор батлуулах;

Арав. Улсын онцгой комиссын нарийн бичгийн дарга, дэд хурандаа Т.Баярхүүд:

10.1. Улсын онцгой комиссын даргын 2021 оны 51 дүгээр тушаалаар батлагдсан “Гадаад улсаас ирсэн хүнийг тусгаарлан ажиглах үйл ажиллагааг зохицуулах түр журам”, Улсын онцгой комиссын даргын 2021 оны 11 дүгээр тушаалаар батлагдсан “Хилийн Алтанбулаг авто замын боомтоор улс хоорондын ачаа тээврийн хөдөлгөөнийг зохион байгуулах түр журам”-ыг хүчингүй болгох;

10.2. Улсын онцгой комиссын даргын 2021 оны 46 дугаар тушаалаар батлагдсан “Хот болон орон нутаг хооронд иргэдийн зорчих хөдөлгөөнийг зохицуулах түр журам”-д холбогдох байгууллагуудаас санал авч нэмэлт өөрчлөлтийг оруулах;

Арван нэг. Улсын онцгой комиссын гишүүн, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын тэргүүн дэд дарга Б.Ганбат, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын дарга Б.Цэнгэл нарт:

11.1. Орхон аймаг дахь Коронавируст халдвар /Ковид-19/-ын хүндрэлтэй нөхцөл байдал, эмнэлэг, тусгаарлан эмчлэх байрны хүрэлцээгүй зэргийг харгалзан “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ын хөрөнгө оруулалтаар баригдаж, гэрээний үндсэн дээр “Медипас” ХХК-д шилжүүлсэн Эрдэнэт медицина төв эмнэлэг /хуучин нэрээр/-тэй холбоотой асуудлыг Монгол Улсын Засгийн газрын хуралдаанд танилцуулж, шийдвэрлүүлэх;

Шийдвэрийн биелэлтийг тооцож, танилцуулж ажиллахыг Улсын онцгой комиссын Нарийн бичгийн дарга, дэд хурандаа Т.Баярхүү, Шуурхай штабын дарга, хурандаа Ц.Ганзориг нарт даалгах.

ДАРГА

С.АМАРСАЙХАН

НАРИЙН БИЧГИЙН ДАРГА,
ДЭД ХУРАНДАА

Т.БАЯРХҮҮ

УЛСЫН ОНЦГОЙ КОМИССЫН
ШУУРХАЙ АЖЛЫН ХЭСГИЙН
ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2021.10.12
16.30

Улаанбаатар хот
Төрийн ордон

Улсын онцгой комиссын Шуурхай ажлын хэсэг 2021 оны 10 дугаар сарын 12-ны өдрийн 16.30 цагт Шадар сайдын өрөөнд хуралдав. Хурлыг Монгол Улсын Шадар сайд, Улсын онцгой комиссын дарга С.Амарсайхан даргалж, Онцгой байдлын ерөнхий газрын дарга, хошууч генерал Г.Ариунбуян, УОК-ын Нарийн бичгийн дарга Т.Баярхүү, Шадар сайдын ахлах зөвлөх бөгөөд Ажлын албаны дарга Ц.Уртнасан, Улсын онцгой комиссын Нэгдсэн шуурхай штабын дарга, бригадын генерал Б.Ууганбаяр, орлогч дарга, хурандаа Ж.Амгалан нар оролцов. Хурлаар коронавируст халдвар /Ковид-19/-ын нөхцөл байдал, хариу арга хэмжээний талаар мэдээлэл сонсож, Монгол Улсын Шадар сайд, Улсын онцгой комиссын дарга С.Амарсайхан хугацаатай үүрэг даалгавар өгөв.

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

1. Бүх шатны Засаг дарга нар нутаг дэвсгэрийн хэмжээнд коронавируст халдвар /Ковид-19/-ын эсрэг авч хэрэгжүүлж буй хариу арга хэмжээ биечлэн удирдлага, зохион байгуулалтаар хангаж ажиллах.

Аймаг, нийслэлийн Засаг дарга нарт

2. Нийслэл, орон нутгийн эмнэлгүүд, өрхийн эрүүл мэндийн төвүүдэд эм, эмнэлгийн хэрэгслийн нөөц бүрдүүлэлт, эм, тариа, тусламж үйлчилгээний чанар стандартад нэг бүрчлэн хяналт шалгалт зохион байгуулах, шалгалтын үр дүнд дүн шинжилгээ хийж Улсын онцгой комисст 2021 оны 11 дүгээр сарын 1-ний дотор танилцуулах.

*Эрүүл мэндийн сайд С.Энхболд,
аймаг, нийслэлийн Засаг дарга нарт*

3. Байгууллага, ажлын байрны халдварын нөхцөл байдалд эрсдэлийн үнэлгээ хийж тодорхой хувийг цахимаар болон зайнаас ажиллуулах зэргээр эрсдэлт бүлгийг /өндөр настай, архаг суурь өвчтэй, жирэмсэн, бага насны хүүхэдтэй гэх мэт/ халдвараас хамгаалах, халдвар тархах эрсдэлээс урьдчилан сэргийлж ажиллах,

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын тэргүүн дэд дарга Б.Ганбат

4. Коронавируст халдвар /Ковид-19/-ын эсрэг хариу арга хэмжээ авч хэрэгжүүлэх, мэдээлэл, судалгаа хийх шуурхай штабыг Боловсрол шинжлэх ухааны яаманд тогтмол ажиллуулах, халдвараас урьдчилан сэргийлэх, тусгай шаардлага, журмыг мөрдүүлж, хэрэгжилтэд хяналт тавих ажилд бүх шатны боловсролын байгууллагуудын оролцоог хангах,

*Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан,
Аймаг, нийслэлийн Засаг дарга нарт*

5. Эм, эмнэлгийн хэрэгсэл, оношлуурын шаардлагатай нөөцийг бүрдүүлж, коронавируст халдвар /Ковид-19/-ын эмчилгээнд ашиглаж байгаа Ремдесивир, Тоцилизумаб зэрэг эмийг үйлдвэрлэгчээс худалдан авч, эрүүл мэндийн байгууллагуудад нийлүүлэх ажлыг зохион байгуулах, үнийн өсөлтөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авч хэрэгжүүлэх.

Эрүүл мэндийн сайд С.Энхболд

6. Монгол Улсын хэмжээнд гамшгаас хамгаалах бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэн хугацаанд төрийн болон нутгийн захиргааны байгууллага, иргэн, хуулийн этгээдийг замын хөдөлгөөнд автомашинаар оролцох зөвшөөрөл /QR код/ -ийг орчин үеийн мэдээллийн технологийн шийдэлд тулгуурлан ашиглахад хялбар байдлаар бүтээх, бүртгэлжүүлэх ажлын хэсгийг Улсын онцгой комиссын даргын 2021 оны 4 дүгээр сарын 9-ний өдрийн 34 дүгээр тушаалаар байгуулагдсан ажлын хэсэгт даалгасан. Уг тушаалын хэрэгжилтийг хангаж, хийсэн ажлын талаарх тайланг Улсын онцгой комисст 2021 оны 10 дугаар сарын 15-ны өдөр танилцуулах.

Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газрын дарга Б.Болор-Эрдэнэ

7. Коронавируст халдвар /Ковид-19/-ын үеийн телемедицины тусламж үйлчилгээг 2021 оны 10 дугаар сарын 20-ны өдрийн дотор эхлүүлэх

Нийслэлийн эрүүл мэндийн газрын дарга Б.Бямбадорж

8. Шуурхай хурлаар өгсөн үүргийн хэрэгжилтэд хяналт тавьж, тайланг тухай бүр Улсын онцгой комиссын Ажлын албанд танилцуулах.

Улсын онцгой комиссын Нэгдсэн шуурхай штабын дарга, бригадын генерал Б.Ууганбаяр

УЛСЫН ОНЦГОЙ КОМИСС

Хянасан:

УОК-ын Нарийн бичгийн дарга,
дэд хурандаа

[Signature]
Т.Баярхүү

Тэмдэглэл хөтөлсөн:

УОК-ын Ажлын албаны мэргэжилтэн,
дэслэгч

[Signature]
Ж.Бундхорол